МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2023.11.06 № 03/2053

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Хүсэлт хүргүүлэх тухай

Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүргийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах нийт 319 заалт байгаагаас 242 заалтыг хасуулах саналтай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтээс бүрэн хэрэгжсэн, яамны чиг үүрэгт хамааралгүй үндэслэлээр цахим сангаас хасуулах хүсэлтийг удаа дараа мэдэгдсэн боловч цахим сангийн хэрэгжилт гаргах заалтын жагсаалтад хэвээр тусгагдсаар ирсэн.

Цахим системээс хасуулах заалтын мэдээлэл

| д/д | Шийдвэр | Заалтын тоо | Хасагдах заалт | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2023 онд бүрэн хэрэгжсэн | Чиг үүрэгт хамаарахгүй | 2017-2022 онд бүрэн хэрэгжсэн |
| 1 | МУ-ын хууль | 41 | 28 | 2 | 5 | 16 |
| 2 | УИХ-ын тогтоол | 50 | 46 | 5 | 17 | 24 |
| 3 | УИХ-ын Байнгын Хорооны тогтоол | 58 | 55 | - | 53 | 2 |
| 4 | Ерөнхийлөгчийн зарлиг | 3 | 3 | - | 1 | 2 |
| 5 | ЗГ-ын тогтоол | 53 | 37 | 19 | 5 | 13 |
| 6 | Ерөнхий сайдын захирамж | 7 | 5 | 5 | - | - |
| 7 | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 101 | 64 | 39 | 14 | 11 |
| 8 | ЗГ-ын албан даалгавар | 4 | 4 | 1 | 1 | 2 |
| | **Нийт** | **319** | **242** | **71** | **101** | **70** |

232417

Иймд бүрэн хэрэгжсэн, тус яамны чиг үүрэгт хамаарахгүй болон өмнөх онд бүрэн хэрэгжсэн хавсралтад заасан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг цахим сангаас хасуулахаар хүргүүлж байна.

Хавсралт: 81 хуудастай.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА И.БАТХҮҮ

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2023 оны 11 дугаар сарын 06 өдрийн
03/2053 тоот албан бичгийн хавсралт

**Эдийн засаг, хөгжлийн яамны Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /2023 оны 10 дугаар сарын 31/**

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1. | 1. | 2021-12-24. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль/ 2021-12-24/ МУ-ын хууль | 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.5-т "Энэ журмын 3.2.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2-3 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлдэг бөгөөд 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэхээр нэгтгэн боловсруулж байна. Иймд энэ хуулийн заалт нь Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд Чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 2. | 2. | | 20.4. Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.2-т заасны дагуу үндсэн 9 зорилго 47 зорилтын хүрээнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 9 зорилгын хэрэгжилт дунджаар 69.03 хувьтай гарсан бөгөөд "зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай" гэж үнэлэгдсэн. Уг бодлогын хүрээнд "2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлагдаагүй, он тус бүрээр зорилтот түвшнийг тодорхойлсон шалгуур үзүүлэлт байхгүй тул үйл ажиллагааны 2022 оны явцыг хэрэгжүүлэгч байгууллага тус бүрээс ирүүлсэн хэрэгжилтийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн сан /www.unelgee.gov.mn/-гаар баталгаажуулан, хяналтад авч нэгтгэсэн бөгөөд 16 яам, 5 агентлаг, нийслэл, 20 аймгаас тайланг хугацаандаа ирүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу уг бодлогын 2022 оны хэрэгжилтэд хийсэн явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/1565 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх ажлыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас гүйцэтгэх тул хэрэгжилтийг тус байгууллагаас гаргана. Хасуулах саналтай. | | | |
| 3. | 3. | | 19.5. Засгийн газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт | Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын эхний үе шатны үйл | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн төсөл, Монгол Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг яамд, байгууллагуудаас ирүүлсэн тайланд үндэслэн боловсруулж Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/1566 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх ажлыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас гүйцэтгэх тул хэрэгжилтийг тус байгууллагаас гаргана. Хасуулах саналтай. | | | |
| 4. | 4. | | 18.5. Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 2022 оны жилийн эцсийн улсын хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/75 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлж, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улмаар "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ний биелэлтийг Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Төрийн байгууллалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2023 оны 03 | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар сарын 21-ний өдөр, Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд Эдийн засаг, хөгжлийн яамнаас хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг яамны дотоод бүтцийн нэгжүүдээс нэгтгэн авч Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нийтлэг журмын дагуу үнэлгээ хийж сар бүрийн 10-ний дотор www.unelgee.gov.mn цахим системд хэрэгжилтийг тайлагнаж ажилласан. Мөн "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 02/1164 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | | | |
| 5. | 5. | | 17.2. Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг яамд, байгууллагуудаас ирүүлснийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, танилцуулга, холбогдох тайлангийн хамт Засгийн | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/74 албан бичгээр хүргүүлсэн. Улмаар “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийг Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 05 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр, Улсын Их Хурлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний эхний хагас жилийн хэрэгжилтийг гаргах хүрээнд яамд, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн Засаг дарга нарт “Хэрэгжилт ирүүлэх тухай” 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/965 тоот албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд хэрэгжилтийг баталгаажуулж ирүүлсэн 16 яам, 21 аймгийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын хавсралтын дагуу нэгтэн боловсруулж, хяналт-шинжилгээ үнэлгээг хийж, 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 02/1164 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх ажлыг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | газраас гүйцэтгэсэн тул хэрэгжилтийг тус байгууллагаас гаргана. Хасуулах саналтай. | | | |
| 6. | 6. | | 15.3. Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. | Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлж ажилладаг.<br>Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдаагүй тул тус яамнаас хэрэгжилт гаргах боломжгүй байна. Хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 7. | 7. | 2023.01.01. Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ / 2022-06-17 / МУ-ын хууль | 2.3.2. Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг харгалзан тогтооно. | Зөвшөөрлийн хуулийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамнаас олгох зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг тогтоосон. Ингэхдээ Төрийн нийтийн өмч буюу байгалийн баялгийг ашиглахтай холбоотой зохицуулалтууд, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох 248 зөвшөөрөл, иргэн болон өрхийн мөн нэг удаагийн 114 энгийн зөвшөөрлийг кодолсон тул хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 8. | 8. | | 3.3.3. Энэ зүйлийн 1-д заасан эрх шилжүүлэх журмыг Засгийн газар батална. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 9. | 9. | | 7.1.5. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам"-ын төслийг хэлэлцүүлэн батлуулсан тул хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 10. | 10. | 2022.05.01. Нийтийн мэдээллийн ил тод | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн | Тайлбар: төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хүн, хуулийн этгээдтэй | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлын тухай / 2021-12-17 / МУ-ын хууль | этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | холбоотой асуудал нь тус яамны чиг үүрэгт Чиг үүрэгт хамаарахгүй байх тул хасуулах саналтай. | | | |
| 11. | 11. | | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Тайлбар: төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хүн, хуулийн этгээдтэй холбоотой асуудал нь тус яамны чиг үүрэгт Чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 12. | 12. | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/136 тушаалаар батлуулсныг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулсан. Уг төлөвлөгөөнд 39 арга хэмжээний 8,183.3 сая төгрөгийг төлөвлөсөн. Үүнээс 28 арга хэмжээний 7,413.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээг байгуулан 4,785.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 11 арга хэмжээний 770.0 сая төгрөгийн ажил нь тендер шалгаруулалтын шатандаа байна. Тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг албан бичгээр тендерт оролцогчдод тухай бүр хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 13. | 13. | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Төсвийн шууд захирагчийн аудитлагдсан тайланг хүлээн авч нэгтгэн, төсвийн тухай | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 03/504 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн ба тус газраас 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтээр өөрчлөлтгүй санал дүгнэлтийг ирүүлсэн. Аудитлагдсан санхүүгийн тайланг хуулийн хугацаанд буюу 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03/666 дугаар албан бичгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэн ажилласан тул хасуулах саналтай. | | | |
| 14. | 14. | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/97 тушаалаар албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлгээг баталгаажуулах чиг үүрэг бүхий үнэлгээний багийг нэгжийн дарга нарын болон хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Засгийн газрын мэдээллийн цахим сан (www.plan.igoverment.mn)-д нийт албан хаагчид гүйцэтгэлийн тайланг цахим хэлбэрээр тайлагнаж, нэгжийн дарга нар үнэлгээг баталгаажуулсан бөгөөд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Үнэлгээний багийн хурлаар албан хаагч тус бүрээр үнэлгээг баталгаажуулсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар Төрийн нарийн бичгийн даргын буюу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хэлэлцэж 97.0 буюу "А" үнэлсэн.<br>Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Журам шинэчлэн батлах тухай 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтуудыг дагаж мөрдөн ажиллаж байна. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэхтэй холбоотой журам, шийдвэрүүдийг шинэчлэн байгууллагын https://www.med.gov.mn/ цахим хуудсанд байршуулж ажилласан. Хасуулах саналтай. | | | |
| 15. | 15. | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Засгийн газрын тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр байгуулагдсан. Тус яамны хүний нөөцийн бодлого, зорилт нь шударга, эрх тэгш, зэрэг таатай орчныг бий болгож байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тулгуурлан байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, судалж сонгох, ажилд томилох, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах, ажилтнуудын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор тэдгээрийн албан тушаалыг залгамжлах хүмүүсийг тодорхойлох, албан тушаалд сэлгэн, шилжүүлэн ажиллуулах зэрэг хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршиж байна. Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийн дагуу дараах асуудлуудад төвлөрсөн.<br>Хүний нөөцийн удирдлагын хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хүний нөөцийн бодлогын бичиг баримт, төрийн албаны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх, тухайн албан тушаалд хувь хүний мэдлэг, боловсрол мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагыг шалгуур болгон түүнийг хамгийн сайн хангаж байгаа хүнийг сонгон шалгаруулж томилох, сонгон шалгаруулах үндсийг | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоосон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, зөвшөөрөл авах, батлуулах цаг хугацаа хүчин чармайлт шаардсан томоохон ажлыг хэрэгжүүллээ. Үүнд:<br>1.Албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог бүрдүүлсэн;<br>2.Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой үр ашигтай байх зарчимд нийцүүлэх арга хэмжээ авсан;<br>3.Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, томилох, сургаж хөгжүүлэх бодлого зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлсэн;<br>4.Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөрийг батлуулсан;<br>5.Ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх хөтөлбөр зэргийг боловсруулж батлуулсан. | | | |
| 16. | 16. | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, тус хуулийг дагалдуулан гарсан дүрэм, журмын дагуу яамны албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх, бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Төрийн албаны эрх зүйн шинэ орчны хүрээнд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдаж уулан гарсан болон Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм, журмууд, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журмууд, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулахтай ийн холбогдох журам болон үнэлэх журмуудыг байгууллагын https://www.med.gov.mn/ цахим хуудсанд шинэчлэн байршуулсан. Засгийн газрын мэдээллийн цахим санд (www.plan. igovernment.mn)-д нэвтрүүлж албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг цахим хэлбэрээр тайлагнахаар оруулж Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/97 тоот тушаалаар Үнэлгээний баг байгуулж, 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар албан хаагч тус бүрийн үнэлгээг хийж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 97.0 хувь буюу А үнэлгээгээр үнэлэгдсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тоот тушаалаар "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр"-ийг баталж, яамны 2023 оны сургалтын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр батлан хэрэгжүүлж байна. | | | |
| 17. | 17. | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг байгууллагын https://med.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/91 тоот тушаалаар Ёс зүйн хороог байгуулж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан. Эдийн засаг, хөгжлийн яамны Ёс зүйн хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангах ажиллаж байна. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 18. | 18. | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудас https://med.gov.mn/ хүний нөөцийн ил тод үйл ажиллагаа хэсэгт байршуулсан болно. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд сул орон тооны зарыг тухай бүр байршуулан 26 орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлаж, 36 хүн бүртгүүлэн 26 хүн шалгалтад орсноос 26 иргэн тэнцэж төрийн албанд жинхлэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | томилогдсон. Мөн 9 орон тоог сэлгэн шилжүүлэхээр зарлаж 7 албан хаагчийг томилсон байна. | | | |
| 19. | 19. | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам загвар батлах" тухай 17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 5 дугаар хавсралтын дагуу ажлын байрны сул орон тооны мэдээллийг гарган холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд яамны med.gov.mn цахим хуудсандаа тавьж олон нийтэд зарлаж байна. Шилэн дансны тухай хуулийн 6.4.7-т заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээг сар бүрийн 8-ний дотор олон нийтэд мэдээлж ил тод болгон мэдээлж байна. Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 03-ны 161 дүгээр тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн яамны үйл ажиллагааны зохион байгуулалтын стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлагдсан бөгөөд 135 орон тоотой батлагдсан. Одоогийн байдлаар 81 хүн ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолт 2013 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн ТАЗ-ийн 413-417 тогтоолоор батлуулсан бөгөөд сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 20. | 20. | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А-98 тоот тушаалаар "Зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн орон тоо, албан тушаалын жагсаалт"-ыг баталж, чиг үүргийн шинжилгээ хийж албан тушаалын | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тодорхойлолтыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 03/1157 тоот албан бичгээр албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрлийн хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, 2023 оны 10 дугар сарын 06-ны өдрийн 413, 414, 415, 416, 417 дугаар тогтоолоор батлуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамны med.gov.mn цахим хуудаст албан хаагчдын овог нэр, харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг, өрөөний дугаарыг нээлттэй мэдээлж, тухай бүр шинэчилж байна. | | | |
| 21. | 21. | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Эдийн засаг, хөгжлийн яамны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр батлуулж, шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn-д байршуулсан яамны 2023 оны 1-4 дүгээр сарын мэдээлэл оруулсан байдалд 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрийг дуусталх хугацаанд дотоод аудит хийж, хэрэгжилтийг үнэлж, цаашид анхаарах асуудлын тухайд, 5 санал боловсруулж, улмаар дотоод аудитын тайланг яамны удирдлагад 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр танилцуулсан. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 22. | 22. | | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 161 дүгээр тогтоолоор "Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны зохион байгуулалтын стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тооны дээд хязгаар"-ыг баталсан. Тус хөтөлбөрийн 2.1-т "Үйл ажиллагааны стратегийн мөн чанар", 2.2-т "Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл", 2.3-т "Эрхэм зорилго", 2.4-т "Стратегийн зорилт" болон эдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтуудыг тодорхойлсон. Яамны үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд Монгол Улсын | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг боловсруулан Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны хуралдаанаар, УИХ-ын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-г 39 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг ном хэлбэрээр яамны цахим хуудаст нээлттэй байршуулсан.<br>"Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл, арга хэмжээний жилийн эцсийн биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2022 оны жилийн эцсийн тайланд нийтлэг журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж тайлагнасан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороодын хуралдаанаар 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хэлэлцүүлэн, 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан. | | | |
| 23. | 23. | 2020.07.01. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ / 2020-05-07 / МУ-ын хууль | 9.4.9. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журам батлах; | Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны А-141 тоот тушаалаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам"-ыг шинэчлэн баталсан. /Хасуулах саналтай/ | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 24. | 24. | | 7.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэн нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллана. | Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт өөрчлөлт орж, Макро эдийн засгийн бодлогын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс байгуулагдаж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа энэ газарт хамаарч байгаа тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25. | 25. | | 7.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг байгуулахаар шийдвэрлэж, Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оноос эхлэн байгуулагдсан.<br>Салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэж байна.<br>Хэрэгжсэн тул хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 26. | 26. | 2020.07.01. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ / 2020-05-07 / МУ-ын хууль | 9.3.8. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журам болон тайлангийн үлгэрчилсэн загварыг тус тус батлах; /Энэ заалтыг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан. | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журам болон тайлангийн үлгэрчилсэн загварыг тус тус баталсан.<br>Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 62 дугаар тушаалаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандоржоор ахлуулж байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн гишүүнээр ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна.<br>Дээрх ажлын хэсгийн төлөвлөгөөнд заасны дагуу 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр "Төрийн бүтээмж ба үнэлгээ, мониторинг" хэлэлцүүлгийг зохион | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулсан. Тус хэлэлцүүлгээр 1/Үнэлгээ, мониторингийн өнөөгийн нөхцөл байдал, 2/Үнэлгээ, мониторингийн олон улсын туршлага, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцсэн. Энэ хэлэлцүүлэгт ЭЗХЯ-ны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга "Хөгжлийн бодлого, төлөвлөлт"-ийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага" сэдвээр илтгэл хэлэлцүүлж, панелистаар оролцсон.<br>Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль" болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах талаар санал боловсруулахтай холбогдуулан Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын хамтарсан 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/42, А/149 дугаартай ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарсан.<br>2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын ажлын хэсгийн гишүүдтэй хамтран хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Тус ажлын хэсгийн хэлэлцүүлгээр хуулийн нэр томьёо, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын эрх, үүргийн талаарх өөрчлөлтүүдийг хэлэлцэж хуулийн төсөл дээр санал солилцож, олон улсын онол, практикийг судалж ажилласан. | | | |
| 27. | 27. | | 21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д тусгагдсаны дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2021 оны явцын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 2/35 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, УИХ-ын байнгын хороодын | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022 оны 3 дугаар сарын 31-нд УИХ-д танилцуулсан. | | | |
| 28 | 28. | 2023.05.04. Аялал жуулчлалын тухай / 2023-05-04 / МУ-ын хууль | 20.4. Үндэсний хорооны ажиллах журмыг Засгийн газар батална. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| 29. | 1. | 2016 №34. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2016-04-14 / УИХ-ын тогтоол | 8. "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө"-г батлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлүүлж байх. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 30. | 2. | | 7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх; | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 31. | 3. | 2023 №67. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай / 2023-07-06 / УИХ-ын тогтоол | 4/. Зээлийн үйлчилгээний төлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү их байгаад дүгнэлт хийж, цаашид төсвийг бодитой төлөвлөж ажиллах. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 32. | 4. | | 3/. Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж байх; | Монгол Улсын тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар болон төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн баталсан төсвөөс зөрүүтэй зарцуулсан шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргаж Үндэсний Аудитын газарт хүргүүлсэн. Хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 33. | 5. | 2023 №48. Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай / 2023-06-16 | 1.5. төрөөс хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах чиглэлээр аж ахуйн нэгжүүдэд олгодог хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулан шийдвэрлүүлэх; | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 34. | 6. | | 1.3. валютын цэвэр дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх чиглэлээр экспортыг | Хөгжлийн түнш орнууд, олон улсын байгууллагатай хийж буй хамтын | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, импортын орц их шаарддаг томоохон төсөл, арга хэмжээг төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөллийг харгалзан хэрэгжүүлэх; | ажиллагаанд баримтлах стратегийг харилцан тохиролцох, холбогдох хэлэлцээ хийх арга хэмжээг УИХ, ЗГ-ын шийдвэртэй уялдуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Шинэ сэргэлтийн бодлогод туссан 33 хөгжлийн төсөл, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан 186 төслийн бэлэн байдлыг сайжруулах, санхүүжилтийн эх үүсвэр эрэлхийлэх ажлын хүрээнд Дэлхийн банк, АХБ, ЕСБХБ, "ЖАЙКА", "Эм Юү Эф Жи" банк, Хятадын үйлдвэр, худалдааны банк, "Си Ди Пи Кү", олон улсын хөрөнгө оруулалтын групп, гадаад улсуудын ЭСЯ, Солонгосын гадаад худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг, хөрөнгө оруулагч, хөгжлийн түнш байгууллагуудтай уулзаж, төслүүдийн мэдээллийг тогтмол танилцуулан ажиллаж байна. Мөн санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй төслүүдийг санхүүжүүлэхээр Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 300.0-400.0 сая ам доллар хүртэлх хөрөнгө оруулалт яриа хэлэлцээрийн түвшинд явж байна. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/23 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/"-ын хүрээнд 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж бэлэн байдал хангагдаагүй 151 төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлэсэн. Ингэснээр бэлэн байдал хангагдсан төслүүдэд хөрөнгө оруулагч нарыг татах боломж бүрдэж байна.<br>Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай байна. | | | |
| 35. | 7. | | 2.2/. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга | Төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр туссан төсөл арга хэмжээний бэлтгэлийг хангах хүрээнд Төр, хувийн хэвшлийн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээнд шаардагдах бэлтгэл ажлыг хангаж ажиллах; | түншлэлийн тухай хуульд заасан дагалдах дүрэм, журам, аргачлалын төслийг боловсруулж, яамдаас болон иргэд олон нийтээс санал авч, ирсэн саналыг тусган журмын төслийг эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлэн болсон тул хасуулах саналтай.хэрэгжүүлэх үндсэн бэлтгэл ажил хангагдаж байгаа болно. | | | |
| 36. | 8. | | 2.1/. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай: 1/Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах; | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах нь Сангийн яамны асуудал тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 37. | 9. | 2023 №26. Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос Монгол Улсын хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт , үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай / 2023-04-21 / УИХ-ын тогтоол | 3.2. Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцад хийсэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтны хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 38. | 10. | | 3.1. 1/Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явцын талаар хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлж, Хөгжлийн банкийг цогцоор нь иж бүрэн өөрчлөн зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, 2023 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 39. | 11. | 2023 №25. Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай / 2023-04-21 / УИХ-ын тогтоол | 1.5. "Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн хуулийн этгээдтэй өрсөлдөхгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 394 дүгээр тогтоолоор"Хөдөө аж ахуйн корпорац" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Хүнс, хөдөө аж ахуй, | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөнгөн үйлдвэрийн яамыг тогтоосон байх тул уг заалтыг хасуулах саналтай байна. | | | |
| 40. | 12. | | 3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоолоор Засгийн газрын шийдвэргүйгээр төлбөрийг ашигт малтмал, түүхий эдээр төлөх нөхцөлтэй /off-take/ бүх төрлийн шинэ гэрээ байгуулахыг зогсоохыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон экспортлох эрх бүхий төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагыг томилох эрх бүхий этгээд, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, гүйцэтгэх удирдлагад тус тус даалгаж, орон нутгийн өмч давамгайлсан эрх бүхий этгээдэд зөвлөсөн.<br>Тус арга хэмжээний заалт хэрэгжсэн тул хасуулах саналтай байна | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 41. | 13. | 2023 №08. Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай / 2023-01-19 / УИХ-ын тогтоол | 2/а. а/"Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх хүрээнд 2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж, 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулах; | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд хамаарахгүй тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 147. | 15. | Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023-05-17 Дугаар 2023_178 | 1.1. “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх арга хэмжээг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, | "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг заасан хугацаанд багтаан эхлүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд холбогдох байгууллагуудын оролцоог хангаж, ажиллах ажлын хэсэг байгуулахаар Сангийн яам, Цахим хөгжил, харилцаа | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөрөнгө оруулалт, худалдааны газар, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал)-т; | холбооны яам, Гаалийн ерөнхий газарт нэр авах тухай Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 03/1154 тоот албан бичгийг хүргүүлэн хариуг авч ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг хуралдан бүрэлдэхүүнийг шинэчилсэн. Ажлын хэсгийн хүрээнд тодорхой үүрэг даалгаврыг өгч, судалгаа хийлгэн мэдээлэл солилцсон. Иргэн, хуулийн этгээдээс шаардагддаг бичиг баримт, бүрдүүлбэрийн судалгаа холбогдох байгууллагуудаас авч нэгтгэсэн. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажлын хэсэг хуралдахаар бэлтгэж байна. Явцын биелэлт 100 хувь. Урт хугацаанд үргэлжлэх ажил. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 148. | 16. | | 1.2. "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл /RIBS/ -ийн хүрээнд 3.6 сая ам.долларын зээлийн санхүүжилтээр уг ажлыг гүйцэтгэхээр ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. /Биелэлт 100 хувь/<br><br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 149. | 17. | | 6. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | Тогтоолыг хэрэгжүүлэх асуудлаар хамтран ажиллах асуудлаар ЭЗХЯ-аас холбогдох байгууллагуудад тухай бүр албан бичгээр хандан ажилласан.<br><br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 150. | 18. | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар гүйцэтгүүлэх тухай 2023-02-08 Дугаар 2023_59 | 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй. | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар гүйцэтгүүлж, арилжааны үйл явцын гүйцэтгэлийн мэдээллийг сар бүр авч хэрэгжилтэд хяналт хийж ажиллаж байна. 2023 оны 2 дугаар сарын 9-ны өдрөөс эхлэн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа эхлүүлж, 7 дугаар сарын 31-ний байдлаар 45 цахим арилжааг амжилттай зохион байгуулсан байна.<br><br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 151. | 19. | 2023_37. Агентлаг байгуулах тухай / 2023-02-01 / ЗГ-ын тогтоол | 3. "Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг батлаж, мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай | Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлагдаж хэвийн үйл ажиллагаа явагдаж байгаа тул хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 152 | 20. | 2023_120. Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2023-04-05 / ЗГ-ын тогтоол | 3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудалд Чиг үүрэгт хамаарахгүй байх тул хасуулах саналтай. | 100 | 100 | Чиг үүрэгт хамаарахгүй |
| 153. | 21. | | 2.3. "Хот хөдөөгийн сэргэлт"-ийн хүрээнд нийгэм, эдийн засгийн бүсчлэл тогтоох схем, арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийн төв боомтуудын тусгайлсан орон зайн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн дарга нарт; | Монгол Улсын "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл"-ийг шинэчлэн боловсруулахдаа байршлын ерөнхий онол, бүс нутгийн онол, бүс нутгийн хөгжлийн онол, кластерийн онол, шинэ эдийн засаг-газар зүйн онол, нутаг дэвсгэрийн жигд бус хөгжлийн тухай онол, диффузийн онол, аж ахуйн орон зайн зохион байгуулалтын онол, зөгийн үүр загвар, төв байршлын онол, веберийн аж үйлдвэрийн байршлын онолын ем, нийгэм эдийн засгийн бүсчлэл тогтоох ем, арга зүй аргачлалыг ашигласан. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд орон зайн судалгаа, тооцоолол, аргазүйн үүднээс Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн зангилаа 7 байршил болон орон нутгийн ХАА-н түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх орон нутгийн 69 төвүүдийг тодорхойлон салбарын яамд болон Шинжлэх ухааны академи, эрдэмтэдтэй хэлэлцэн төслийн эцсийн хувилбарыг боловсруулан Засгийн газар, УИХ-т өргөн мэдүүлэхээр бэлтгээд байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 66 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт шаардлагатай мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 154. | 22. | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 4. Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах ажлын хүрээнд орон нутагт шилжин суурьших иргэдэд тодорхой урамшуулал олгоход, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн яам (Ч.Хүрэлбаатар), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Б.Бат-Эрдэнэ), Сангийн яам (Б.Жавхлан), Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Д.Амарбаясгалан)-т тус тус даалгасугай. | Монгол Улсын 2023 оны 68 дугаар тогтоолоор орон нутагт шилжин суурьших иргэдэд үзүүлэх дэмжлэгүүд батлагдсан. Мөн Монгол Улсын 2023 оны төсөвт УБ хотоос орон нутагт шилжих суурьших иргэдийн ажиллаж амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр бага хүүтэй орон сууцны зээл/2023 онд нийт 5600 иргэнд дээрх зээлийг олгохоор тооцож, хүүгийн зөрүү буюу төрөөс хариуцаж төлөх 8.0 тэрбум төгрөг, бага хүүтэй бизнесийн зээл 2023 онд нийт 100.0 тэрбум төгрөгийн зээл олгогдохоор тооцож, зээлийн хүүгийн зөрүүнд 12.9 тэрбум төгрөг/ орон нутгийн нэмэгдэл 2023 онд 217.0 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2023 онд 1.0 их наяд төгрөг/-ийн төсөв тусгагдсан. Орон нутгийн бизнесийг дэмжих 1 хувийн хүүтэй 500 хүртэлх сая төгрөгийн зээлийг олгохоор тогтсон. Мөн орон нутагт бизнес эрхэлж байгаа гарааны бизнесийн эхний таван жил татвараас бүрэн чөлөөлөх зохицуулалтууд хийгдэнэ. Энэ ажлын хувьд ЗГ-ын 68 дугаар тогтоол болон Улсын төсөвт дараах дэмжлэгүүд туссан тул хасуулах саналтай байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 155. | 23. | | 5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/735 тоот албан бичгээр Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй "Цагааннуур", "Алтанбулаг", "Замын-Үүд" чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны орон нутаг руу шилжүүлэх боломжтой 75 орон тооны мэдээллийг хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 156. | 24. | 2022_488. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод | 5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг шинэчлэн тогтоох тухай / 2022-12-28 / 3Г-ын тогтоол | хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэн ажиллаж байна. Сайдын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн А/50 дугаар тушаалаар ТҮ шатлалаар 40 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн. "1.Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу дэд болон хэмнэх албан тушаалтны орон тоо байхгүй болно. 2.Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлж, батлуулсан. 3.Тус яам 2023 онд зохион байгуулсан сургалтуудыг цахимаар зохион байгуулахад анхаарч ажиллаж байна. 4.Эдийн засаг, хөгжлийн яам нь 2023 онд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулаагүй, төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно." Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 157. | 25. | Улаанбаатар хотын "Шинэ тойрог зам"-ыг барьж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476 | 3. Туулын авто зам, гүүрэн байгууламж, Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто зам, Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэлх авто замыг тус тус "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д концессын боломжит төрлийг сонгон тусгуулж, ажлын тоо хэмжээ, цар хүрээгээр багцлан зөвлөх болон гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус даалгасугай. | ЗТХЯ-аас 2023 оны 04 сарын 28-ны өдрийн 01/1954 дугаартай албан бичгээр "Шинэ тойрог зам"" төслийн урд хэсэг "Туулын авто зам"" төслийг Засгийн газрын 2023 оны 317 дугаар тогтоолоор батлан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгах санал ирүүлсэн. Ирүүлсэн саналыг судлан, танилцаж ЗТХЯ-нд дахин сайжруулж ирүүлэх тухай хариуг хүргүүлж, ЗТХЯ-ны 2023 оны 01/2480 тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу ЭЗХЯ-ны 2023 оны 01/1047 тоот албан бичгээр "Шинэ тойрог зам" төслийн урд хэсэг "Туулын авто зам" төслийг ТӨЮЖ-д тусгах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамнуудаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 02/1174 дугаар албан | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 253 дугаар тогтоолоор "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д нэмэлтээр тусгагдаад байна. Тус тогтоолын 3 дахь хэсэгт төслүүдийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгаад байна.<br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 158. | 26. | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-11-23<br>Дугаар 2022_413 | 2.7. "Алтай дайхан холдингс" ХХК-ийн газрын тусгай зөвшөөрлийг орон нутгаас хүчингүй болгосонтой холбоотой үүссэн гомдлыг судалж, хуулийн дагуу шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж нарт. | Тус заалтад ЗГХЭГ, Сэлэнгэ аймгийн ЗД-д даалгасан тул хасуулах саналтай.Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/135 тоот албан бичгээр "Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 413 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар мэдээлэл ирүүлэхийг холбогдох 11 төрийн байгууллага, албан тушаалтан (Эрчим хүчний сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Шадар сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрчим хүчний зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Сэлэнгэ аймгийн Засаг дарга)-д хүргүүлсэн. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тус тогтоолын хэрэгжилтийн талаар дараах агуулга бүхий албан бичгийг Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн: -2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр ХЭГ/359 тоот "Биелэлт хүргүүлэх тухай" албан бичгээр "Сэлэнгэ аймгийн Засаг дарга "Ажлын хэсэг байгуулах тухай" захирамж гаргаж, "Алтай дайхан холдингс" ХХК-аас холбогдох материалыг авч судлах, Жавхлант сумын удирдлагууд, тус компанийн төлөөлөлтэй | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | уулзаж асуудлыг шийдвэрлэх боломжийг судлан ажиллаж байгаа талаар; -2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр ХЭГ/783 тоот "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгээр Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/363 тоот "Мэдээлэл хүргүүлэх тухай" албан бичгийг уламжлан ирүүлсэн. Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 01/363 тоот албан бичигт "Алтай дайхан холдингс" ХХК-д Жавхлант сумын нутаг дэвсгэрт тариалангийн газрыг дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар газар ашиглуулах боломжтой гэж үзэж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа талаар мэдээллийг ирүүлсэн. Иймд хасуулах саналтай. | | | |
| 159. | 27. | | 3. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | ЭЗХЯ, ГХЯ-д хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасан тул хасуулах саналтай байна.<br>"Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 413 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Мэдээлэл ирүүлэх тухай 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/135 тоот албан бичгийг холбогдох 11 төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнээс дараах 5 байгууллагын хэрэгжилтийн явцыг тус тус хүлээн авсан. - Эрчим хүчний зохицуулах хорооноос 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/93 тоот албан бичгээр явц; -Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/986 тоот албан бичгээр дээрх тогтоолын хэрэгжилтийг ирүүлсэн. - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хэг/539 тоот албан бичгээр ирүүлсэн. Сэлэнгэ аймгийн Засаг даргад даалгасан ажлын биелэлтийн тайланг ирүүлсэн. - Хууль зүй, дотоод хэргийн яаманд Цагдаагийн ерөнхий газраас хүргүүлсэн гомдолд дурдсан асуудлаарх эрүүгийн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байцаан шийтгэх ажиллагааны талаарх биелэлт; - Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас Шадар сайдын Ажлын албанд тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн. - Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2023.04.06-ны өдрийн 03/1847 тоот албан бичгээр "Юнигаз" ХХК-ийн санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. - Барилга, хот байгуулалтын яамны 2023.03.03-ны өдрийн 2/746 тоот "Мэдээлэл ирүүлэх тухай" албан бичгээр биелэлтийн тайланг ирүүлсэн. | | | |
| 160. | 28. | | 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах саналаа томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хүргүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай. | Эдийн засаг, хөгжлийн яамнаас 5 дугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар 3Г-ын 413 дугаар тогтоолын биелэлтийн талаар танилцуулсан. Уг тогтоолын хүрээнд "Юнигаз" ХХК-ийн төлбөр тооцоотой холбоотой гомдол болон "Кинкора коппер лимитед" ХХК-ийн газар ашиглах эрхтэй холбоотой гомдлууд шийдвэрлэгдсэн. Үлдсэн 30 аж ахуйн нэгжийн гомдол шийдвэрлэгдээгүйгээс сэргээгдэх эрчим хүчний салбарын 20, хууль хяналтын байгууллагаас шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа 2, төрийн захиргааны байгууллагаас судалгаа хийхээр хүлээгдэж байгаа 1, хувийн хэвшил хооронд үүссэн 4 гомдол болон гомдол гаргагчаас гомдол, хүсэлт ирүүлээгүй 1 гомдол байна. Түүнчлэн, уг тогтоолоор Өрсөлдөөний тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт гадаадын хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж буй эсэхийг судлах ажиллагааг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасан.<br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 161. | 29. | "Цагааннуур" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай | 2. "Цагааннуур" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан гааль, мэргэжлийн хяналт, дотоодын цэрэг зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн албадын үйл ажиллагаа явуулах бэлтгэл | 1/Цагааннуур чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан мэргэжлийн үйл ажиллагааг хангаж ажилласан. 2/Баян-Өлгий аймгийн Гаалийн газар, Баян- | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-11-23 Дугаар 2022_412 | ажлыг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт, Цагааннуур тосгоноос чөлөөт бүс хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд тус тус үүрэг болгосугай. | Өлгий аймгийн Цагдаагийн газраас чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах Гаалийн албан хаагчдад шаардагдах техник хэрэгсэл, интернэтийн асуудлыг шийдвэрлэн үйл ажиллагаа эхлээд байна. Шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлүүлж өгөх хүсэлтийн дагуу Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас чөлөөт бүсийн хашаа болон нэг цэгийн үйлчилгээний төвд нийд 20.0 сая төгрөгийн өртөг бүхий хяналтын камер байрлуулж, хэвийн ажиллаж эхэлсэн. 3/Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг Инженер геодези ХХК хийж гүйцэтгэж байгаа бөгөөд инженерийн шугам сүлжээний зурвас тогтоох зураг боловсруулах ажил дуусах шатандаа орсныг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн уулзалтын үед мэдэгдсэн. Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой 27 зургийг файлаар, 18 ширхэг 3D зураг зэрэг баримт мэдээллийг хүлээлгэн өгсөн тул хасуулах саналтай. | | | |
| 162. | 30. | | 3. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай зардлыг 2023 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | 1/Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдох зарим зардлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэсэн. 2/Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл /Баян-Өлгий, Ногооннуур сумын 9-р баг Цагааннуур тосгон/ гэсэн нэршлээр 250.0 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2023 оны төсөвт тусгасан. Хасуулах саналтай. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 163. | 31. | 2022_466. Журам батлах тухай / 2022-12-14 / ЗГ-ын тогтоол | 2. Энэ тогтоолын 1-д заасан цахим арилжаанд хяналт тавих журмыг хамтран баталж, мөрдүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд | Засгийн газрын хуралдааны 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр нүүрсний цахим биржийн анхны | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт үүрэг болгож, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй. | арилжааны туршилт амжилттай хийгдсэн. "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаанд тавих хяналтын журам" 2023 оны 1 дүгээр сарын 27-ны ЭЗХЯ, УУХҮЯ, СЗХ-ны хамтарсан тушаалаар батлагдсан. 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 7,469 мянган тонн нүүрсийг нээлттэй арилжсан бөгөөд үүнээс 3,110 мянган тонн нүүрсийг цахим арилжаагаар, 4,358 мянган тонн нүүрсийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр тус тус арилжсан байна. Мөн 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш 101 мянган тонн төмрийн баяжмалыг биржээр дамжуулан арилжаад байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгавар хэрэгжсэн тул хасуулах саналтай байна. | | | |
| 164. | 32. | 2022_460. Жагсаалт батлах тухай / 2022-12-14 / ЗГ-ын тогтоол | 2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох ТЕЗ нарт даалгасан тул хасуулах саналтай Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын II.2.4.1-д Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/"-ын 5хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар баталж жагсаалтыг Засгийн газрын 2022 оны 460 дүгээр тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| 165. | 33. | 2022_448. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн | "1.Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу дэд болон хэмнэх албан тушаалтны орон тоо байхгүй болно. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай / 2022-12-07 / ЗГ-ын тогтоол | хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | 2.Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлж, батлуулсан. 3.Тус яам 2023 онд зохион байгуулсан сургалтуудыг цахимаар зохион байгуулахад анхаарч ажиллаж байна. 4.Эдийн засаг, хөгжлийн яам нь 2023 онд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулаагүй, төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно." Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн<br><br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 166. | 34. | 2022_450. "Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 2022-12-09 / ЗГ-ын тогтоол | 3.5. . компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | "Засгийн газрын 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд удирдлага, зохион байгуулалт, өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй ажлын үр дүн, тулгамдаж буй асуудлуудыг Засгийн газрын хуралдаанд 14 хоног тутам танилцуулж, Засгийн газрын хуралдааны 7 тэмдэглэл гарч, холбогдох Засгийн газрын гишүүн, албан тушаалтнуудад өгөгдсөний үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Уг ажлын хүрээнд ""Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 385 дугаар тогтоол, "Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 450 дугаар тогтоолын хэрэгжилтийг | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биелэлтэд байнгын хяналт тавьж ажилласан." Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн<br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 167. | 35. | "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-10-26<br>Дугаар 2022_385 | 3. 3. Онцгой дэглэмийн хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтанд даалгасугай: 3.1. компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, шинэчлэх, шаардлагатай бол нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.2. компанийн хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.3. Тавантолгой нүүрсний ордоос нүүрс ачих, тээвэрлэх, худалдан борлуулах, хил нэвтрүүлэх бүхий л үе шатанд хяналтыг сайжруулах шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад, энэ чиглэлээр бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; 3.4. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; 3.5. "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад. | Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг 2 долоо хоног тутам буюу 2022 онд нийт 5 удаа, 2023 оны 7 сарын 31-ний байдлаар нийт 11 удаа Засгийн газрын хуралдаанд танилцууллаа. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд төрийн өмчит болон бусад холбогдох ашигт малтмал экспортлогчид, болон бусад холбогдох байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд тогтмол хяналт тавьж ажиллав. Мөн тус компаниас валютын орлого төвлөрүүлэх, экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн гэрээг ил тод болгох чиглэлээр цогц ажлууд авч хэрэгжүүлсэн.<br><br>Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 168. | 36. | "Замын-Үүд" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай 2021-07-28 Дугаар 2021_223 | 3. Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа хилийн бүсэд барих авто замын улсын хил нэвтрэх цэг, байршил тогтоох асуудлаар Хятадын талтай хэлэлцэн тохиролцох, хилийн хяналтын цэг байгуулах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай. | Замын-Үүд" чөлөөт бүсийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 223 дугаар тогтоолоор байнгын үйл ажиллагаанд шилжүүлсэн. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/08 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж Эрээний чөлөөт бүстэй шууд харилцах механизм бүрдүүлсэн. Азийн хөгжлийн банкны 30 сая эм.долларын санхүүжилтээр "Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд CS-01 буюу "Замын-Үүд" чөлөөт бүсийн дэд бүтэц болон барилга байгууламж барьж ашиглалтад оруулах инженерийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулах компани шалгаран зураг, төслийг боловсруулж дууссан. Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн Монголын талын бүрэлдэхүүний хуралдааныг зохион байгуулах замаар арга хэмжээг авч ажиллаж байна. Монголын талын хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн хуралдааныг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хуралдуулсан. Уг хуралдаанаар анхдугаар гүйцэтгэх зөвлөлийн хуралдааныг 2023 оны III улиралд багтаан хуралдуулах, хил дамнасан байгууламжийн улсын хилийн шугамын дайран гарах цэгийн байршлыг тохиролцох, протокол үйлдэж, дипломат шугамаар харилцан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай саналыг 2023.08.02-ны өдрийн 02/1318 дугаартай албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. Замын-Үүд чөлөөт бүсийн газар зохион байгуулалт, нэгж талбайн хуваарилалт, хэмжээ болон эргэлтийн цэг тогтоох, байр зүйн дэвсгэр зураглалын ажилд ашиглах зорилгоор South Galaxy G1 маркийн багц төхөөрөмжийг худалдан авахаар шийдвэрлээд байна. Хасуулах саналтай/ | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 169. | 37. | 2022_7. Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай / 2022-01-05 / ЗГ-ын тогтоол | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | Бүрэн хэрэгжсэн тул хасуулах саналтай байна. | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 170. | 1. | 2023_55. Ажлын хэсэг байгуулах тухай / 2023-03-23 / Ерөнхий сайдын захирамж | 2. Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай: 2.Солонгосын талтай хэлэлцээ хийх Монголын талын багийг томилж, баримтлах удирдамжийг батлан ажиллуулахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасугай. 3.Хэлэлцээний явц, үр дүнг шаардлагатай тухай бүр нь танилцуулж байхыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 онд 2 дугаар сард БНСУ-д хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний дэд сайд Ил Жүн Парк нар "Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр"-ийг байгуулах хэлэлцээг эхлүүлэх тухай "Хамтарсан мэдэгдэл"-д гарын үсэг зурсан. Дээрх "Хамтарсан мэдэгдэл"-д үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 55 дугаар захирамжаар "Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ байгуулах ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсэг" байгуулагдсан болно. Уг захирамжаар Солонгосын талтай хэлэлцээ хийх Монголын багийг томилж, баримтлах удирдамжийг батлан ажиллуулахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасны дагуу | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/47 дугаар тушаалаар "Хэлэлцээний баг"-ийг байгуулсан. Монголын талын Хэлэлцээний багийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Солонгосын талын Хэлэлцээний багийн ахлагчаар БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Чөлөөт худалдааны хэлэлцээрийн бодлогын газрын дарга (Dr. Changyong Ahn) нар томилогдон ажиллаж байна. Дээрх тушаалаар Хэлэлцээрийн бүлэг тус бүрээр холбогдох байгууллагуудын оролцоог хангасан ажлын хэсгүүдийг байгуулан, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангаж, баримтлах удирдамжийг батлан ажиллахыг Хэлэлцээний багийн ахлагчид үүрэг болгосны дагуу Бүлгийн ажлын хэсгүүдийг байгуулахаар ажиллаж буй бөгөөд холбогдох нийт 35 байгууллагаар ажлын хэсэгт нэр авахаар 2023 оны 05 сарын 23-ны өдөр 03/884 дугаар албан бичгийг хүргүүлсэн | | | |
| 171. | 2. | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2023-03-03<br>Дугаар 2023_44 | 2. Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийх ажлын айлчлалыг зохион байгуулах бэлтгэл хангах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай: Ажлын айлчлалын бэлтгэл хангах шуурхай арга хэмжээг авч, зохион байгуулж, ажиллахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайд 2023 оны 06 дугаар сарын 26-аас 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн. Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар айлчлалын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг ахалж ажилласан ба айлчлалын хүрээнд дараах уулзалтуудыг хамтран зохион байгуулж биечлэн оролцсон. Үүнд: 1) БНХАУ, Тяньжин хотод Дэлхийн эдийн засгийн форумд оролцож мөн 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Тяньжин хотын Тяньжин боомтын үйл ажиллагаатай танилцсан. 2) БНХАУ, Бээжин хотод: а) Албан ёсны уулзалт хэлэлцээр - 2023 оны 6 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Чянтай албан ёсны хэлэлцээ хийж, БНХАУ-ын дарга Ши Жиньпин болон Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Жао Лэжид тус тус бараалхсан. b) Монгол Хятадын Бизнес | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | форум- 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдөр Монгол-Хятадын нийт 500 гаруй бизнес эрхлэгчдийн хамтарсан форумыг зохион байгуулж оролцсон. Энэ үеэр нийт 10 салбарын (уул уурхай, эрчим хүч, барилга, хүнс хөдөө аж ахуй, аялал жуулчлал, гадаад худалдаа, цахим худалдаа, тээвэр логистик, соёл урлаг, эрүүл мэнд) 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд санамж бичиг, гэрээнд гарын үсэг зурсан ба гэрээний үнийн дүн ойролцоогоор 2.2 тэрбум юань хүрсэн. c) БНХАУ-ын томоохон ААН-тэй хийх уулзалт- Чайна Энержи, CNPC, Power China, CCCC, Norinco, TBEA зэрэг Хятадын томоохон аж ахуйн нэгжийн төлөөллүүдтэй ажил хэргийн цуврал уулзалтуудыг хийсэн. 3) БНХАУ, Нинбо хот: a) Жөжян мужийн удирдлагатай хийх уулзалт- Жөжян мужийн удирдлагатай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд гангийн үйлдвэр байгуулах чиглэлд хамтран ажиллахаар талууд тохиролцсон. b) Томоохон үйлдвэрүүдтэй танилцах уулзалт- "Нинбо гангийн үйлдвэр", "Нинбо Жинтянь зэс үйлдвэрлэл" ХХК, "Консайни групп". Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 172. | 3. | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2023-03-03<br>Дугаар 2023_43 | 2. "Монголын эдийн засгийн чуулган-2023"-ыг Улаанбаатар хотноо 2023 оны 07 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгуулсугай. "Монголын эдийн засгийн чуулган-2023"-ы хөтөлбөрийг боловсруулж, олон улсын болон төв, орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч, арга хэмжээний зардлын төсвийг нарийвчлан тооцож, холбогдох арга хэмжээ авахыг Ажлын хэсэг (Ч.Хүрэлбаатар)-т даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 43 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурал 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр төрийн ордонд зохион байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хурлаар "Монголын эдийн чуулган-2023" зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд хийгдсэн ажлуудыг танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд чуулган зохион байгуулахтай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг танилцуулахаар Засгийн газрын тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/1053 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн гадаад, дотоодын оролцогчид, хөрөнгө | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулагчид, ивээн тэтгэгч хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний хуралдааны 25 дугаар тэмдэглэл батлагдсан. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд "Монголын эдийн засгийн чуулган-2023"-ыг зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан бүх яамд, ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн. "Монголын эдийн засгийн чуулган-2023"-ыг зохион байгуулах дэд ажлын хэсгийг салбар хуралдаан тус бүрээр байгуулан 2023 оны 06 дугаар сарын 28-ний өдөр цахимаар зохион байгуулж чиглэл өгч ажилласан. 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ээлжит хурлыг "Төрийн ордны Үндэс" хуулийн танхимд зохион байгуулсан. Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд "Монголын эдийн засгийн чуулган-2023"-ны дэд ажлын хэсгүүдийг нэгдсэн зохион байгуулалт, ажлын уялдаа, холбоог хангаж, үүрэгжүүлж тухай бүр хяналт тавьж ажилласан. "Монголын эдийн засгийн чуулган 2023"-ыг "Монголд тавтай морил" уриан дор 2023 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн чуулганаар манай улсын эдийн засгийг тэлэх, төрөлжүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг Монгол Улсын Засгийн газар Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 173. | 4. | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2023-02-06<br>Дугаар 2023_29 | 2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцыг дүгнэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах бодлогын баримт бичгийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг агуулгын хувьд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт болон холбогдох төрийн албан хаагчдад таниулах арга хэмжээ авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Санал, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дүнгээ 2023 оны 03 дугаар сарын 03- | Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 29 дүгээр захирамжаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцыг дүгнэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах бодлогын баримт бичгийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг агуулгын хувд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт болон холбогдох төрийн албан хаагчдад танилцуулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр ажлын төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Түвдэндорж)-т даалгасугай. | 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр бодлогын баримт бичгийн 1-9 зорилгын тайланг цахим хэлбэрээр хүлээн авч нэгтгэсэн. Улмаар Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд тусгах мэдээллийг эцэслэн бэлтгэх хүрээнд тоон мэдээлэл, зураг, графикаар баяжуулж, тайлангийн дизайн сайжруулах ажлыг яамд, байгууллагуудын оролцоотой гүйцэтгэсэн. Тус ажлын хэсэг "Шинэ сэргэлтийн бодлого" анхан шат-2023 хэлэлцүүлгийн арга хэмжээг 1 нэгдсэн хуралдаан, 9 салбар хуралдаан/Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот/-тайгаар 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Уг арга хэмжээнд бүх аймаг, сум, багийн Засаг дарга нараас бүрдсэн 3000 төлөөлөгч оролцож, Монгол Улсын Засгийн газраас баримталж буй урт хугацааны хөгжлийн бодлогын талаар нэгдсэн ойлголт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харилцан санал солилцсон. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| 174. | 5. | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2023-02-03<br>Дугаар 2023_26 | 3. "Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт"-ыг Олон Улсын Худалдааны Төвийн дэмжлэг оролцоотойгоор Улаанбаатар хотноо 2023 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсугай.<br>2.Чуулга уулзалтыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай: Чуулга уулзалтын бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулж, ажлын явцыг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Түвдэндорж)-т даалгасугай. | Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор, Олон улсын худалдааны төвийн дэмжлэг, оролцоотойгоор 2023 оны 06 дугаар сарын 26- 29-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Тус чуулга уулзалтыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсэг нийт 8 удаа танхим болон цахимаар хуралдаж, шаардлагатай танилцуулга, шийдвэрийг тухай бүр гарган ажиллав. Тус үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой зарим ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/75 тоот тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хорооны ажлын хэсэг 5 удаа хуралдаж, | 100 | 100 | Бүрэн хэрэгжсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | холбогдох тендерийн баримт бичгийг боловсруулж, сонгон шалгаруулах үйл ажиллагааг явууллаа. Чуулга уулзалтыг амжилттай зохион байгуулав. 70 улс орноос нийт 600 төлөөлөгч оролцсон. Чуулга уулзалтын тайланг 2023 оны 7 дугаар сард 26-нд Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
